ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## Хэнтий аймгийн Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХЭА-2025/027/НА-СТА-ТШЗ**

Чингис хот

2025 он


Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 Цахим хаяг:khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Н.Туяа
Утас: 99799709 Цахим хаяг:tuyan@audit.gov.mn

Цахим хаяг: www.audit.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна у

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2025.02.20 № 100

танай ______________ -ны № ________________ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН АРДЫН ДУУ БҮЖГИЙН ХАН ХЭНТИЙ ЧУУЛГЫН ДАРГА Д.ЦОГТ-ЭРДЭНЭ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус байгууллага нь тайлант онд улсын төсвөөс 2,994,366.4 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 829,121.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 219,295.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагаанд 4,044,766.4 мянган төгрөгийг зарцуулан, 94,948.7 мянган төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулга нь 2024 онд аймгийн Засаг даргын захирамжаар бүтэц орон тоогоо шинэчлэн 132 хүний орон тоо батлуулан, уран бүтээлийн цирк анги, драмм ангийг шинээр байгуулан 2 салбар, 9 нэгж ангитай ажиллаж байна.

Тус чуулга нь 2024 онд өөрийн бэлтгэн найруулсан уран бүтээлээр Дорнод, Говьсүмбэр, Дорноговь аймаг болон ОХУ-ын Өвөр байгалийн хязгаарын 10 мужаар аялан тоглолт хийж, 50,270.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Тус чуулгын барилга 2012-2023 онд улсын төсвийн хөрөнгөөр баригдан 2023 оны 9 дүгээр сард ашиглалтад орсон боловч Төрийн өмчийн Бодлого зохицуулалтын газраас уг барилгыг орлогод авах зөвшөөрлийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт 2024 оны 12 сард ирүүлсэн боловч үнийн дүн зөрүүтэй байгаагаас одоог хүртэл нягтлан бодох бүртгэлд орлогоор бүртгээгүй байна.

232502100

**Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 69,488.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 56,552.9 мянган төгрөгөөр дутуу тусгасан алдааг санхүүгийн тайланд залруулсан.

Мөн цалингийн зардлыг нийгмийн даатгалын зардлаас төлж цалингийн зардлыг 10,296.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн зөрчилд албан шаардлагыг хүргүүлж, түрээсийн орлогоос төсөвт төвлөрүүлэх орлогыг 2,640.0 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 40 арга хэмжээ тусгаж, хэрэгжилт 98 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **237,744,912.74** | **117,955,037.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **96,931,884.74** | **-** |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **96,931,884.74** | **-** |
| **3121** | **Төгрөг** | **96,931,884.74** | **-** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 96,931,884.74 | - |
| **33** | **АВЛАГА** | - | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | | |
| **335** | **Бусад авлага** | - | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **140,813,028.00** | **117,955,037.00** |
| **351** | **Түүхий эд материал** | **59,851,000.00** | **24,649,000.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 59,851,000.00 | 24,649,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **61,132,028.00** | **87,006,037.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 220,000.00 | 704,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 59,702,028.00 | 86,302,037.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,210,000.00 | - |
| 35600 | Мал амьтад | 19,830,000.00 | 6,300,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **998,066,633.30** | **1,314,375,300.20** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **998,066,633.30** | **1,314,375,300.20** |
| **392** | **Биет хөрөнгө** | **782,566,633.30** | **1,098,875,300.20** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 711,288,128.00 | 711,288,128.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (703,099,460.20) | (703,361,363.44) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 15,000,000.00 | 15,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (4,999,999.92) | (7,499,999.88) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 576,397,512.00 | 766,366,537.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (194,618,860.13) | (281,491,013.81) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 374,119,284.00 | 625,484,284.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (78,677,529.33) | (147,497,924.58) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 265,632,149.98 | 325,715,649.98 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (178,474,591.10) | (205,128,997.07) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **215,500,000.00** | **215,500,000.00** |
| 39301 | Программ хангамж | 400,000.00 | 400,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (400,000.00) | (400,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 216,000,000.00 | 216,000,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (500,000.00) | (500,000.00) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,235,811,546.04** | **1,432,330,337.20** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **413** | **Өглөг** | - | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,235,811,546.04** | **1,432,330,337.20** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,235,811,546.04** | **1,432,330,337.20** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,754,595,398.00 | 2,754,595,398.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 2,754,595,398.00 | 2,754,595,398.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **(1,602,279,611.55)** | **(1,405,760,820.39)** |

| | | | |
|---|---|---|---|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (1,602,279,611.55) | (1,602,279,611.55) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 196,518,791.16 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 83,495,759.59 | 83,495,759.59 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,235,811,546.04** | **1,432,330,337.20** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,340,118,739.94** | **4,542,231,262.06** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **103,645,850.00** | **718,743,345.73** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 103,645,850.00 | 718,743,345.73 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 103,645,850.00 | 718,743,345.73 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 219,295,245.73 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 103,645,850.00 | 499,448,100.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,236,472,889.94** | **3,823,487,916.33** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | - | **2,994,366,416.33** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 2,994,366,416.33 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **178,800,490.00** | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 25,000,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 153,800,490.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **545,133,000.00** | **829,121,500.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 829,121,500.00 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 545,133,000.00 | - |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | **1,512,539,399.94** | - |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,512,539,399.94 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,246,898,801.64** | **4,345,712,470.90** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,246,898,801.64** | **4,345,712,470.90** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,994,362,741.67** | **4,202,778,841.51** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,014,130,795.90** | **2,499,686,972.23** |
| 210101 | Үндсэн цалин | 775,384,862.90 | 1,630,232,458.79 |
| 210102 | Нэмэгдэл | 106,309,347.00 | 595,008,997.29 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 48,073,500.00 | 93,520,556.50 |
| 210104 | Урамшуулал | 84,363,086.00 | 180,924,959.65 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **125,248,277.98** | **313,656,768.24** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 86,587,258.82 | 213,293,481.06 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,184,472.00 | 25,089,619.43 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,138,777.66 | 12,543,593.47 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,829,624.90 | 12,543,867.60 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,508,144.60 | 50,186,206.68 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **492,443,035.03** | **811,319,069.74** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 20,861,482.28 | 36,393,597.60 |
| 210302 | Түлш, халаалт | 469,507,722.75 | 764,456,882.14 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,073,830.00 | 10,468,590.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **30,896,311.00** | **68,028,786.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,560,160.00 | 6,706,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,837,287.00 | 27,909,506.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 818,400.00 | 883,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 781,000.00 | 132,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 14,899,464.00 | 32,396,780.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **350,000.00** | **-** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 350,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **46,432,404.00** | **21,652,050.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,308,000.00 | 1,472,250.00 |
| 210602 | Тавилга | - | 2,100,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 1,503,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 44,124,404.00 | 16,576,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **9,482,000.00** | **11,638,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,482,000.00 | 11,638,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **113,879,820.00** | **72,941,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 113,699,820.00 | 72,761,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 180,000.00 | 180,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **161,500,097.76** | **403,856,195.30** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 69,002,679.00 | 218,747,337.20 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 92,497,418.76 | 185,108,858.10 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **252,536,059.97** | **142,933,629.39** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **246,883,800.00** | **47,984,953.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 10,600,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 63,189,300.00 | 20,536,953.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 167,052,500.00 | 16,848,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,642,000.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **-** | **94,948,676.39** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 94,948,676.39 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **5,652,259.97** | **-** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,652,259.97 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **93,219,938.30** | **196,518,791.16** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **93,219,938.30** | **196,518,791.16** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан** **/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,236,472,889.94** | **4,042,783,162.06** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **219,295,245.73** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 219,295,245.73 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | - | **219,295,245.73** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 219,295,245.73 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,236,472,889.94** | **3,823,487,916.33** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | - | **2,994,366,416.33** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 2,994,366,416.33 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **178,800,490.00** | **-** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 25,000,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 153,800,490.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **545,133,000.00** | **829,121,500.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | - | 829,121,500.00 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 545,133,000.00 | - |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | **1,512,539,399.94** | **-** |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,512,539,399.94 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,152,288,230.88** | **4,062,142,446.80** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,152,288,230.88** | **4,062,142,446.80** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,899,752,170.91** | **3,919,208,817.41** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,014,130,795.90** | **2,499,686,972.23** |
| 210101 | Үндсэн цалин | 726,537,071.70 | 1,630,232,458.79 |
| 210102 | Нэмэгдэл | 155,336,416.69 | 595,008,997.29 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 47,919,668.07 | 93,520,556.50 |
| 210104 | Урамшуулал | 84,337,639.44 | 180,924,959.65 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **125,248,277.98** | **313,656,768.24** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 86,587,258.82 | 213,293,481.06 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,184,472.00 | 25,089,619.43 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,138,777.66 | 12,543,593.47 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,829,624.90 | 12,543,867.60 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,508,144.60 | 50,186,206.68 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **492,443,035.03** | **811,319,069.74** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 20,861,482.28 | 36,393,597.60 |
| 210302 | Түлш, халаалт | 469,507,722.75 | 764,456,882.14 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,073,830.00 | 10,468,590.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **27,820,587.00** | **59,820,806.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,851,500.00 | 7,190,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,047,287.00 | 26,699,506.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 803,400.00 | 883,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 781,000.00 | 132,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,337,400.00 | 24,914,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **350,000.00** | **-** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 350,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **69,299,705.00** | **61,634,550.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 19,537,000.00 | 36,147,250.00 |
| 210602 | Тавилга | 1,930,000.00 | 3,600,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 795,000.00 | 4,998,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 47,037,705.00 | 16,888,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **9,482,000.00** | **11,638,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,482,000.00 | 11,638,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **129,612,595.00** | **74,251,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 129,417,595.00 | 74,071,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 195,000.00 | 180,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **31,365,175.00** | **87,201,651.20** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 31,365,175.00 | 87,201,651.20 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **252,536,059.97** | **142,933,629.39** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **246,883,800.00** | **47,984,953.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 10,600,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 63,189,300.00 | 20,536,953.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 167,052,500.00 | 16,848,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,642,000.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | **94,948,676.39** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 94,948,676.39 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **5,652,259.97** | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,652,259.97 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **84,184,659.06** | **(19,359,284.74)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **77,572,600.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **77,572,600.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | **77,572,600.00** |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 77,572,600.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(77,572,600.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **84,184,659.06** | **(96,931,884.74)** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **96,931,884.74** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **96,931,884.74** | **-** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,754,595,398.00** | **83,495,759.59** | **(1,650,432,589.85)** | **1,187,658,567.74** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | **-** | **-** |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,754,595,398.00** | **83,495,759.59** | **(1,650,432,589.85)** | **1,187,658,567.74** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 93,219,938.30 | 93,219,938.30 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,754,595,398.00** | **83,495,759.59** | **(1,602,279,611.55)** | **1,235,811,546.04** |
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **2,754,595,398.00** | **83,495,759.59** | **(1,602,279,611.55)** | **1,235,811,546.04** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | **-** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,754,595,398.00** | **83,495,759.59** | **(1,602,279,611.55)** | **1,235,811,546.04** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин | - | - | - | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 196,518,791.16 | 196,518,791.16 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,754,595,398.00** | **83,495,759.59** | **(1,405,760,820.39)** | **1,432,330,337.20** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | | |
|---|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | **зөрүү** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **4,058,199,900.00** | **4,044,766,370.41** | **13,433,529.59** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,058,199,900.00** | **4,044,766,370.41** | **13,433,529.59** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **4,009,975,900.00** | **3,996,781,417.41** | **13,194,482.59** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **2,509,448,900.00** | **2,499,686,972.23** | **9,761,927.77** |
| 210101 | Үндсэн цалин | 1,638,840,700.00 | 1,630,232,458.79 | 8,608,241.21 |
| 210102 | Нэмэгдэл | 595,009,800.00 | 595,008,997.29 | 802.71 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 94,812,000.00 | 93,520,556.50 | 1,291,443.50 |
| 210104 | Урамшуулал | 180,786,400.00 | 180,924,959.65 | (138,559.65) |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **313,681,300.00** | **313,656,768.24** | **24,531.76** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 213,303,200.00 | 213,293,481.06 | 9,718.94 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 25,094,500.00 | 25,089,619.43 | 4,880.57 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 12,547,300.00 | 12,543,593.47 | 3,706.53 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 12,547,300.00 | 12,543,867.60 | 3,432.40 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 50,189,000.00 | 50,186,206.68 | 2,793.32 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **812,221,500.00** | **811,319,069.74** | **902,430.26** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 36,639,400.00 | 36,393,597.60 | 245,802.40 |
| 210302 | Түлш, халаалт | 764,590,100.00 | 764,456,882.14 | 133,217.86 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,992,000.00 | 10,468,590.00 | 523,410.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **62,132,000.00** | **62,100,606.00** | **31,394.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 7,200,000.00 | 7,190,700.00 | 9,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 26,700,000.00 | 26,699,506.00 | 494.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 900,000.00 | 883,800.00 | 16,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 132,000.00 | 132,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 27,200,000.00 | 27,194,600.00 | 5,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **63,059,000.00** | **63,014,350.00** | **44,650.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 36,159,000.00 | 36,147,250.00 | 11,750.00 |
| 210602 | Тавилга | 5,000,000.00 | 4,979,800.00 | 20,200.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 5,000,000.00 | 4,998,500.00 | 1,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 16,900,000.00 | 16,888,800.00 | 11,200.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **11,700,000.00** | **11,638,000.00** | **62,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 11,700,000.00 | 11,638,000.00 | 62,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **145,911,600.00** | **143,664,500.00** | **2,247,100.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 143,491,600.00 | 143,484,500.00 | 7,100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,000,000.00 | - | 1,000,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,420,000.00 | 180,000.00 | 1,240,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **91,821,600.00** | **91,701,151.20** | **120,448.80** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 91,821,600.00 | 91,701,151.20 | 120,448.80 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **48,224,000.00** | **47,984,953.00** | **239,047.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **48,224,000.00** | **47,984,953.00** | **239,047.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 10,634,600.00 | 10,600,000.00 | 34,600.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 20,741,400.00 | 20,536,953.00 | 204,447.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 16,848,000.00 | 16,848,000.00 | - |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **4,058,199,900.00** | **3,947,834,485.67** | **110,365,414.33** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **2,998,334,500.00** | **2,900,331,370.20** | **98,003,129.80** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,998,334,500.00 | 2,900,331,370.20 | 98,003,129.80 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **829,121,500.00** | **828,207,869.74** | **913,630.26** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 829,121,500.00 | 828,207,869.74 | 913,630.26 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **230,743,900.00** | **219,295,245.73** | **11,448,654.27** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 215,690,000.00 | 219,295,245.73 | (3,605,245.73) |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 15,053,900.00 | | 15,053,900.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **96,931,884.74** | **(96,931,884.74)** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **0** | |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **189** | **174** | **15** |
| 620001 | Удирдах ажилтан | 2 | 2 | - |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 151 | 148 | 3 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 36 | 24 | 12 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

**Аудитын явцад санхүүгийн тайланд 56,552.9 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг залруулсан. Үүнд:**

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 56,552.9 мянган төгрөгөөр дутуу тусгасныг залрууллаа.

**Аудитаар нийт 12,936.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 2,640.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 10,296.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:**

### 3.1 Төлбөрийн акт

Хөрөнгийг түрээслүүлсний орлогоос төсөвт 2,640.0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоосон.

### 3.2 Албан шаардлага

Цалингаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийг эдийн засгийн ангилал зөрүүлэн нийгмийн даатгалын зардлаас төлж цалингийн зардлыг 10,296.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлагыг хүргүүлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: Залруулсан | | Үүнээс: Залруулаг даагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Элэгдлийн зардлыг дутуу тусгасан | **1** | **56,552.9** | **1** | **56,552.9** | | | **1** | **56,552.9** | | | | |
| **Дүн** | **1** | **56,552.9** | **1** | **56,552.9** | | | **1** | **56,552.9** | **0** | **0** | **0** | **0** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Түрээсийн орлогыг дутуу төвлөрүүлсэн | 1 | 2,640.0 | 1 | 2,640.0 | | | | | | | | |
| Эдийн засгийн ангилал зөрүүлсэн | 1 | 10,296.0 | | | 1 | 10,296.0 | | | | | | |
| **Дүн** | **2** | **12,936.0** | **1** | **2,640.0** | **1** | **10,296.0** | | | | | | |

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2025 оны 02 сарын 07 өдөр Дугаар 18-ХЭА/2025/027/НА-СТА-ТШЗ А230447 Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хан Хэнтий чуулгын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсний орлогоос 2,640.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн 40 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох " журмын 4.2.3.2 -д *"Төрийн болон орон нутгийн эд хөрөнгийг түрээслүүлсэн, ашиглуулсны төлбөр болон борлуулсны орлогыг дутуу төвлөрүүлсэн, эсхүл төвлөрүүлээгүй"* гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төсөвт төвлөрүүлээгүй 2,640.0 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хан Хэнтий чуулгын дарга Д.Цогт-Эрдэнэ, нягтлан бодогч М.Нямдорж нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Н.ТУЯА

23255001?

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 07 Дугаар 12-ХЭА-2025/027/НА-СТА-ТШЗ А-2370447 Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Хан Хэнтий чуулгын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд цалингаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэлийн 10,296.0 мянган төгрөгийг эдийн засгийн ангилал зөрүүлэн ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын зардлаас төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан "Урсгал зардлын ангилалын тайлбар" -т заасантай нийцэхгүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д *"хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг эдийн засгийн ангилал зөрүүлэн зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хан Хэнтий чуулгын дарга Д.Цогт-Эрдэнэ, нягтлан бодогч М.Нямдорж нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Н.ТУЯА

232540012

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112